

Улсын бүртгэлийн
дугаар

Нууцын зэрэглэл: Б

Аравтын бүрэн
ангиллын код

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар SSA_2017/20

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН**

"ХАНГАЙН НУРУУНЫ АР БИЕ ДЭХ ТҮҮХ, СОЁЛЫН СУДАЛГАА"

Суурь судалгааны төслийн тайлан

2017-2019

Гүйцэтгэгч

Доктор Д.Баярсайхан,
Магистр Г.Бямбарагчаа, Г.Галбаяр,
Б.Жавхлан, М.Цогбаяр

Удирдагч:

Академич С.Чулуун

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх ухаан технологийн газар

Захиалагч байгууллага:

Боловсрол, Шинжлэх ухаан, Спортын яам

Төслийн өмчлөгч:

ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэн
Улаанбаатар хот 13330 Баянзүрх дүүрэг,
13-р хороо, Энхтайваны өргөн чөлөө
Э-хаяг: history@mas.ac.mn
Утас: 11-458305
Факс: 11-455028

Улсын бүртгэлийн
дугаар

Нууцын зэрэглэл: Б

Аравтын бүрэн
ангиллын код

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар SSA_2017/20

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН**

"ХАНГАЙН НУРУУНЫ АР БИЕ ДЭХ ТҮҮХ, СОЁЛЫН СУДАЛГАА"

Суурь судалгааны төслийн тайлан

2017-2019

Гүйцэтгэгч

Сампилдондовын Чулуун (академич)
Даваасамбуугийн Баярсайхан (доктор),
Ганболдын Бямбарагчаа (ЭША, магистр)
Баатарын Галбаяр (магистр)
Бүдрагчаагийн Жавхлан (магистр)
Мөнхжаргалын Цогбаяр (магистр)

Захиалагч байгууллага:

Боловсрол, Шинжлэх ухаан, Спортын яам

Төслийн өмчлөгч:

ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэн

Улаанбаатар
2019

РЕФЕРАТ

ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэн, Уб-ын Их сургуулийн хамтарсан судалгааны баг 2017-2019 онд «Хангайн нурууны ар бие дэх түүх, соёлын судалгаа» суурь судалгааны төслийг хэрэгжүүлсэн.

Сүүлийн жилүүдэд Монголын түүхийн судалгааны цар хүрээ өргөжин тэлж байгаатай уялдуулан Монгол дахь бүс нутгийн түүх, соёлын өв, баримтжуулалтын талаарх судалгааны шинэ чиг хандлага бий болсоор байна. Үүнтэй уялдуулан Монгол дахь Түүх, соёлын өвийн чиглэлээр судалгаа хийдэг байгууллага, институтууд энэ чиглэлийн судалгааг хийж, тодорхой судалгааны үр дүнгүүдийг гаргаж байна.

Цаг үеийн энэхүү шаардлагыг ТУЗХ-ээс бодит ажил болгон хэрэгжүүлэхийн тулд “Хангайн нурууны ар бие дэх түүх, соёлын судалгаа” суурь судалгааны сэдэвт ажлын төсөл боловсруулж 2017 оны 5 дугаар сарын 29-нд БСШУС сайдын ШуСс-2017/20 тоот тушаалаар дэмжигдсэн билээ.

Энэхүү төсөлт ажлын үр дүнгийн гэрээнд дараах ажлууд тусгагдсан болно. Үүнд,

1. “Хангайн нурууны ар бие Идэр, Тэс голын сав дахь түүх соёлын дурсгалууд” тайлан
2. “Аман түүх, архивын баримтын судалгааны эмхэтгэл” ном,
3. “Хангайн уул орчмоор аялсан жуулчдын тэмдэглэл” тайлан зэрэг болно.

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн С.Бадамхатаны нэрэмжит Угсаатны судалганы салбарын судлаачид, Уб-ын Их сургуулийн Түүхийн тэнхимийн багш нарын хамтарсан судалгааны баг 2017 оны 07 сарын 05-20-ны хооронд Завхан аймгийн хойд болон зүүн хойд, зүүн бүсийн сумууд буюу Хангайн нурууны хойд болон зүүн хойд хэсэгт хамаарах сумуудын нутагт археологи, түүх, угсаатны зүйн хээрийн судалгааг хийж гүйцэтгэлээ. Хээрийн судалгааны ажил нь Түүх, археологийн хүрээлэнгээс явуулж буй “Хангайн нурууны ар бие дэх түүх соёлын судалгаа” сэдэвт төслийн хүрээнд хийгдсэн хээрийн судалгааны ажил байсан.

Тус хээрийн судалгааны ажилд Түүх, археологийн хүрээлэнгийн С.Бадамхатаны нэрэмжит Угсаатны судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан Г.Бямбарагчаа, Улаанбаатарын Их сургуулийн Түүхийн тэнхимийн эрхлэгч доктор (Ph.D), дэд профессор Д.Баярсайхан, тус тэнхимийн багш Г.Галбадрах, Завхан аймгийн аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Б.Жавхлан нар оролцсон бөгөөд төслийн удирдагчаар Түүх, археологийн хүрээлэнгийн захирал доктор (Sc.D), профессор С.Чулуун ажиллав.

Хээрийн судалгааны ажлыг үндсэн 3-н чиглэлээр хийсэн бөгөөд үүнд:

1. Хангайн нурууны ар бие дэх ард түмний түүхэн үйл явц
2. Хангайн нурууны ар бие дэх ард түмний болон газар орны аман түүхийн судалгаа
3. Хангайн нурууны ар бие дэх түүхийн дурсгалт газрууд, археологийн дурсгалуудын бүртгэл, баримтжуулалт гэсэн үндсэн 3-н чиглэлээр судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Бидний хээрийн судалгаа хийсэн бүс нутгуудад дээр дурдсан чиглэлээр судалгаа төдийлэн их хийж байгаагүй бөгөөд ялангуяа түүх, угсаатны зүйн хээрийн судалгаа бараг хийгдээгүй өдийг хүрсэн бүс нутаг юм. Тиймээс энэ бүс нутаг нь түүх, соёл, угсаатны зүйн судалгааны хувьд ихээхэн чухал, анхаарал татах бүс нутаг юм.

Бидний судалгаа хийсэн бүс нутаг нь байршлын хувьд Монгол улсын Баруун Монгол буюу Ойрад угсаатны бүлэг хийгээд халх угсаатны бүлэгт хамаарах хүмүүсийн бараг хил гэж хэлж болох бөгөөд тэр чинээгээрээ түүх, угсаатны зүйн хувьд ихээхэн сонирхолт татах бүс нутаг болох юм.

1950-аад оны сүүл үеэс Монгол улсад эхэлсэн мэргэжлийн угсаатны зүйн хээрийн судалгаа Монгол орны ихэнх бүс нутгуудад хийсээр өнөөг хүрсэн хэдий боловч бидний хээрийн судалгаа хийсэн газарт харьцангуй цөөн удаагийн судалгаа хийсэн, тэр

чинээгээрээ тус бүс нутагт амьдран аж төрж буй ард түмний ахуй соёл, амьдралын хэв төрх, хүн амын бүрэлдэхүүний талаарх мэдээлэл харьцангуй хомс байсаар өдийг хүрчээ. Тиймээс энэ удаагийн хээрийн судалгааны ажил нь судалгааны хувьд ихээхэн ач холбогдол өгөхүйц хээрийн судалгаа болсон юм.

Суурь судалгааны төслийн үр дүн болгож төслийн гүйцэтгэгчид Хангайн нурууны ар бие дэх ард түмний түүх, соёлын өвд холбогдох сэдвийн хүрээнд нэгэн сэдэвт зохиол 1, хамтын бүтээл 3, эрдэм шинжилгээний 10 өгүүлэл, 12 илтгэлийг нийтлүүлж, шинжлэх ухааны эргэлтэд орууллаа.

Түлхүүр үг, гол ойлголтууд:

Хангайн нуруу, түүх, соёлын өв, аман түүх, баримт

ГАРЧИГИЙН МЭДҮҮЛЭГ

Удиртгал	6
Нэг. Үндсэн хэсэг	7
❖ Суурь судалгааны төслийн зорилго	
❖ Судлагдсан байдал, судлах үндэслэл	
❖ Нийгмийн болон шинжлэх ухааны ач холбогдол	
Хоёр. Суурь судалгааны төслийн онол, арга зүйн үндсийн тухай	9
Гурав. Судалгааны үр дүнгийн агуулга	10
❖ Эрдэм шинжилгээний бүтээл	
❖ Эрдэм шинжилгээний өгүүлэл	
❖ Хээрийн судалгаа	
Дүгнэлт.....	43
Хавсралт	47

УДИРТГАЛ

ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэн, Уб-ын их сургуулийн судлаачдын хамтарсан багаас 2017-2019 онд «Хангайн нурууны ар бие дэх түүх, соёлын судалгаа» суурь судалгааны төслийг хэрэгжүүлсэн. Энэхүү суурь судалгааны төслийн гол зорилго нь Монголын баруун төв бүс нутаг буюу Хангайн нурууны ар бие орчмын ард түмний түүх, соёлын өв, аман түүхийн баримтжуулалт хийх, Хангайн нурууны ар биеэр явж өнгөрсөн гадны аялагч, жуулчдын тэмдэглэлүүдийг нэгтгэн хэвлүүлэх, судалгааны эргэлтэд оруулахад оршино.

Хангайн нурууны ар бие дэх ард түмний түүх, соёлын судалгааг хийхдээ үндсэн 4-н чиглэлээр ажилласан бөгөөд археологи, аман түүхийн баримтжуулалт хийх судалгаа, түүхэн баримтжуулалт хийх, тус бүс нутгаар явж өнгөрсөн аялагч, жуулчдын өдрийн тэмдэглэлүүдийг нэгтгэн судалгааны эргэлтэд оруулах гэсэн үндсэн чиглэлээр ажилласан байна. Өмнөх түүх, археологи, угсаатны зүйн чиглэлээр дээр дурдсан бүс нутгаар төдийлэн судалгааны үр дүн гараагүй байв. Тиймээс эрдэм шинжилгээ, судалгааны салбарт дутагдаж байсан дээрх үндсэн 4-н чиглэлээрх судалгааны эх хэрэглэгдэхүүн, баримтуудыг нэгтгэн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, судалгааны эргэлтэд оруулах зэргээр иж бүрэн судалгааг хийж үр дүнг хэвлэн нийтлүүлэх шаардлага урган гарсан юм. Иймд ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэн, Уб-ын их сургуулийн судлаачдын хамтарсан судалгааны баг «Хангайн нурууны ар бие дэх түүх, соёлын судалгаа» суурь судалгааны төслийг 2017-2019 оны хугацаанд хэрэгжүүлэн гүйцэтгэсэн.

2017-2019 онд хэрэгжүүлсэн уг суурь судалгааны төслийн удирдагчаа академич С.Чулуун, гүйцэтгэгчээр доктор Д.Баярсайхан, магистр Г.Бямбарагчаа, Д.Галбаяр, Б.Жавхлан, М.Цогбаяр нар ажилласан болно.

НЭГ. ҮНДСЭН ХЭСЭГ

Сэдэвт ажлын зорилго:

Энэхүү сэдэвт ажлын зорилго нь Монголын түүхийн харилцан адилгүй үеүдэд холбогдох олон хэлний сурвалжийг ашиглаж, түүх, хэл шинжлэл зэрэг олон шинжлэх ухааны судалгааны арга зүйд тулгуурлан, дэлхийн монгол судлалын хүрээнд тодорхой байр суурь эзлэхүйц бүтээл туурвихад оршино.

Сэдэвт ажлын үндэслэл, шаардлага:

“Хангайн нурууны ар бие дэх түүх соёлын судалгаа” сэдэвт ажлыг төлөвлөхдөө Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого, Монгол улсын Шинжлэх ухаан, технологийг 2020 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, Монгол улсад үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр, Монгол улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, Монгол улсын Засгийн газраас баталсан “Монгол судлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”, Монгол улсын Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөрийн зохих заалтыг үндэслэл болгов. Үүнд:

“Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын 3.1.-д заасан “Улс орны хөгжилд чухал ач холбогдол бүхий шинжлэх ухааны суурь судалгааг хөгжүүлэх”;

“Монгол улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-ний 3.4.V-д “Монголчуудын эх хэл, түүх, соёл иргэншил, утга зохиол, урлаг, гүн ухаан, угсаа гарал, зан заншил, уламжлал, зан үйл, аж төрөх хэв маягийн судалгаа”-г нийгэм, хүмүүнлэгийн ухааны тэргүүлэх чиглэлээр тодорхойлсон;

2010 онд шинэчлэгдэн батлагдсан “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 1.1.6, 3.1.4-т тусгагдсан үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх, судлах ажлыг дэмжих;

Монгол улсын Засгийн газраас баталсан “Монгол судлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 3.4.3-т тусгагдсан “Монгол үндэстний гарал үүсэл, түүх соёлыг дэлхий дахинд сурталчлах, үнэн зөв мэдээлэл өгөх”;

Монгол улсын Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөрийн 5.9-т заасан “Монголын түүх, бахархалтай холбоотой түүхэн баримтуудыг судлах, эмхэтгэл гаргаж сурталчлах”;

Монгол улсын ШУА-ийн Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөрийн зорилт зэрэгтэй тус тус нийцэж байна.

Монгол улсын нутаг дахь түүх соёлын дурсгалт зүйлсийн судалгаа хийгдэхдээ их төлөв Хэрлэн, Онон, Туулын сав газар, мөн Орхон голын сав гэсэн үндсэн хоёр чиглэлд хийгдсээр иржээ. Гэтэл Хангайн нурууны ар бие эртнээс нааш хүн оршин амьдарч ирсэн өвөг түүхийн голомт нутгийн нэг болохын дээр нөгөө хоёр бүс нутагтай харьцуулахад бага судлагдсан байгаа нь энэ бүс нутагт нэгдмэл судалгаа зайлшгүй хэрэгтэй байгааг илтгэнэ.

Сэдэвт ажлын шинжлэх ухаан, нийгмийн ач холбогдол:

Хангайн нурууны ар бие дэх түүх соёлын асуудлуудыг шинэ эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан, шинжлэх ухааны үндэслэлтэй шинэлэг байдлаар гаргаж тавьснаар суурь судалгааны төвшинг дээшлүүлж, Монголын түүхийн талаарх шинжлэх ухааны шинэ мэдлэг бий болно. Монголын түүхийн судалгааны баазыг бэхжүүлж, шинэ баримт,

мэдээллээр баяжуулж, суурь судалгааны төвшинг дээшлүүлнэ. Олон нийтийн түүхийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, үндэсний соёл, өв уламжлалаа сэргээн хөгжүүлэхэд тус дөхөм болно. Залуу хойч үеийнхэнд эх оронч үзэл төлөвшүүлэх, түүхийн мэдлэгийг дээшлүүлэхэд зохих нөлөө үзүүлнэ. Ялангуяа дэлхийн эзэнт гүрэн байгуулж мандан бадарч явсан монголчууд бууран доройтож, харь улсын эрхшээлд орж, улмаар дэлхийн хамгийн хоцрогдсон хязгаар болж хувирсан үйл явцыг тодруулан гаргаснаараа нийт монголчуудад түүхийн сургамж, ухаарал, сэхээрэл өгөх ач холбогдолтой.

ХОЁР. СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ОНОЛ, АРГА ЗҮЙН ҮНДСИЙН ТУХАЙ

Суурь судалгааны төслийн хүрээнд Монголын түүх, археологи, угсаатны зүйн шинжлэх ухаанд бүс нутаг судлалын шинэ чиг хандлагыг хөгжүүлэхэд Хангайн нурууны ар бие дэх бүс нутгийн түүх, соёлын судалгааны эх хэрэглэгдэхүүн баримтжуулалтыг ашиглах, судалгааны эргэлтэд оруулах, олон нийтэд түгээх шийдлийг эрэлхийлсэн.

Тус төслийн хүрээнд Монгол дахь түүх соёлын өвийн судалгаанд өөрсдийн хувь нэмрийг оруулах, Монголын баруун бүс нутгийн талаарх судалгааны эх хэрэглэгдэхүүнээр баяжуулсан мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг ашиглах боломжийг нэмэгдүүлэхээр ажилласан болно.

Хангайн нурууны ар биеийн бүс нутаг нь Монголын түүх, археологи, угсаатны зүйн судалгаанд харьцангуй бага хамрагдсан, тойм байдлаар дурдагдах төдий мэдээллийн эх үүсвэртэй байдаг нь тухайн бүс нутагт орших түүх, соёлын өвийн талаарх мэдээлэл дутмаг, тус бүс нутагт түүх, соёлын ямар их өв, мэдээлэл нуугдан буй талаар өнөө хүртэл тэр бүр мэдээлэлгүй байв. Бидний хийсэн энэхүү төслийн хүрээнд энэ хариултад тодорхой хэмжээнд хариулт өгч чадсан бөгөөд ялангуяа Манж Чин гүрний үед хамаарах түүх, соёлын олон арван өвүүд хадгалагдан буйг тодлон харуулсан билээ. Жишээ нь түүх, археологи, аман түүхийн олон арван эх сурвалж, мэдээллүүд үүнийг нотолно. Бидний хийсэн төслийн үр дүнд олон өгүүлэл, хамтын бүтээлүүд хэвлэгдэн, олны хүртээл болоход Монголын түүх, соёлын өвд хамаарах олон арван өвүүдийн талаар олон нийт, судлаачид мэдлэг мэдээлэлтэй болох нь дамжиггүй.

Судалгааны арга зүй, аргачлал:

Судалгааг хийхдээ хээрийн судалгаа, асуулгын арга, бүртгэл тэмдэглэгээжүүлэх аргаар мэдээлэл цуглуулав.

Судалгааны аргачлал:

Хээрийн судалгааг хийхдээ тодорхой бүс нутгийг сонгон авч, тухайн бүс нутаг дахь түүх, соёлын биет өвүүдийг баримтжуулж, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, тухайн бүс нутаг дахь уугуул оршин суугчидтай уулзаж, аман түүхийн мэдээ, эх хэрэглэгдэхүүн цуглуулах, ингэхдээ ярилцах, хүүрнэх арга зүйг түлхүү ашигласан бөгөөд тухайн бүс нутаг дахь эрт үеийн аман түүхийн мэдээ баримтуудыг цуглуулав. Мөн тухайн бүс нутгууд дахь архивын баримт сэлтүүдийг түүвэрлэх, харьцуулах арга зүйн хүрээнд фото баримтжуулалт хийж, мэдээллийн сан үүсгэх аргаар ажиллав.

Бидний төслийн хүрээнд хийсэн судалгааны ажил үндсэндээ Монголын түүхэн дэх түүх, соёлын өвийн баримтжуулалт хийсэн бөгөөд ингэхдээ монголы түүх, археологи, угсаатны зүйн судалгаанд бүс нутаг судлалыг хөгжүүлэх үндсэн зорилготой ажиллаж байсан нь зохих үр дүнгээ өгсөн болно. Өөр хэлбэл Монголын түүх, соёлын өвийн судалгаа тодорхой нэг бүс нутгийн төлөөллөөр хийх боломжтой бөгөөд энэ нь тухайн бүс нутгийн соёлын түүхэн уламжлал зөвхөн угсаатны бүлгийн онцлог бус бүс нутгийн онцлогоор дамжигдан уламжлагдах боломжтой гэсэн судалгааны шинэ чиг хандлагыг дэвшүүлж буйгаараа онцлог болно.

ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН АГУУЛГА

Суурь судалгааны төсөлт ажлын хүрээнд 1-н сэдэвт бүтээл, хамтын бүтээл 2, эрдэм шинжилгээний 10 өгүүлэл судалгааны үр дүн болж гарч байна.

3.1. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛ

Судалгааны нэгэн сэдэвт бүтээл

«Хангайн нурууны ар бие дэх ард түмний түүхэнд холбогдох аман түүх, архивын баримт, аялагчдын тэмдэглэл. Уб., 2019»

Суурь судалгааны төслийн нэгэн гол зорилго бол тухайн бүс нутагт суугаа угсаатны бүлгүүдийн аман түүхийн улбааг мөшгөх, холбогдох архивын баримтыг цуглуулан эмхэтгэн хэвлүүлэх ажил байсан юм. Энэ хүрээнд 2017, 2018 онуудад хээрийн судалгааны ажил хийн аман түүхийн эх сурвалжийг цуглуулан мөн архивын баримт, аялагчдын тэмдэглэл зэргийг илрүүлэн судалгааны эргэлтэнд оруулан хэвлүүлэхэд бэлэн болгов. Нийт 30 орчим хэвлэлийн хуудас бүхий тус номыг хэвлүүлэв.

Дээрх бүтээлийн 1-р бүлэгт Хангайн нурууны ар бие дэх ард түмний аман түүхийн мэдээ, судалгааны эх хэрэглэгдэхүүн орсон болно. Аман түүхийн нийт 10 гаруй аман түүхийн баримт, мэдээнүүдийг нэгтгэсэн бөгөөд түүнээс гадна аман түүхийн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүнийг ямар нэг засвар хийлгүй үндсэх эх сурвалжийг нь тэр чигт нь хэвлүүлэв. Хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүнд нийт 20 орчим гол эх сурвалж өгсөн хүмүүсийн яриануудыг оруулсан болно.

Бүтээлийн 2-р бүлэг нь Хангайн нурууны ар биеийн ард түмний түүхэнд холбогдох архивын баримтуудыг он далааллын шугамд оруулан хуучин Монгол бичгээс орчин үеийн крилл бичигт хөрвүүлэн хэвлүүлэв. Нийт 30 гаруй тооны архивын баримтуудыг нэгтгэн хэвлүүлсэн бөгөөд эдгээр баримтуудын дийлэнх нь Улиастай хотын түүх болоод Засагт хан аймаг, Сайн ноён хан аймгийн зарим хошууд буюу Хангайн нурууны ар биеийн бүс нутагт хамаарах засаг захиргааны нэгжүүдийн түүхэнд холбогдох баримтуудыг оруулав. Он цагийн хувьд XVIII-XX зууны эхэн үе хүртэлх түүхэн үйл явдлуудыг архивын баримтын хэсэгт оруулсан болно.

Бүтээлийн 3-р бүлэг нь Хангайн нурууны ар бие орчмоор XIX зууны төгсгөл үеэс XX зууны эхэн үед явж өнгөрсөн Оросын аялагч, жуулчдын тэмдэглэлүүд орсон болно. Тухайн тэмдэглэлүүдэд Идэр, Тэс, Хануй, Хүнүй, Тамир, Чулуут голын сав дагуу, Тарвагатай, Хангайн нурууны орчим, тус бүс нутаг дахь томоохон нуурууд зэрэг бүс нутгуудын орчмын мэдээ сэлтүүд их гарах ажээ. Нийт 4-н жуулчдын тэмдэглэл орсон нь тухайн үеийн Хангайн нурууны орчмын Монголчуудын амьдралын орчин, сүм хийд, томоохон хотуудын талаар ихээхэн мэдээ, эх сурвалжыг агуулж буйгаараа онцлогтой юм.

Хамтын бүтээл

“Хангайн нурууны ар бие дэх түүх соёлын судалгаа” сэдвийн хүрээнд Завхан аймгийн хойд ба зүүн тал, Хөвсгөл аймгийн урд хэсэг, Архангай аймгийн хойд талын сумуудын нутгийг хамарсан хайгуул, судалгааны ажлыг хийж судалгааны эх хэрэглэгдэхүүн түүвэрлэн цуглуулж судалгааны тайлан бэлэн болгоод байна. Энэ хүрээнд “Хангайн нурууны ар бие дэх хот суурин, сүм хийдийн судалгаа” хэмээх 22,5 хэвлэлийн хуудас тайлан бэлэн болоод байна.

“Хангайн нурууны ар бие, Идэр, Тэс голын сав дахь түүх соёлын судалгаа” сэдвийн хүрээнд тус бүс нутаг дахь түүх соёлын дурсгалт зүйлсийн судалгаа, тодруулбал, булш оршуулга, бууц суурин, хадны зураг, хөшөө чулуудын тухай судалгааны тайлан энэ оны II улиралд багтаж бэлэн болно. Одоогийн явц нь эх хэрэглэгдэхүүнээ бүрэн цуглуулсан, бичилт, найруулгын ажил нь 80 орчим хувьтай байгаа болно. Хавсралт зураг нь багтаад нийт 25 орчим хэвлэлийн хуудас бүхий тайлан хүлээлгэн өгөхөд бэлэн болов.

3.2. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

1. Д.Баярсайхан “Улиастай дахь эртний хотын туурь” УБ., 2017. Volume 13 (12). Тал 71-83. -//“Journal of Archaeology, History and Culture”.
2. Д.Баярсайхан “Алдархааны зургаан ангийнхан буюу Дашпунцаглин хийдийн харьяатын түүхэн тойм” УБ., 2017. Тал 155-166. -//“STUDIA ETHNOLOGICA” Tomus XXV, Fasciculus 11.
3. Г.Бямбарагчаа “Завхан аймгийн орон нутаг судлах музейгээс хээрийн судалгаа явуулж байсан тухай” УБ., 2017. “Музей судлал” сэтгүүл.
4. С.Чулуун “XVII зууны Монголын хотууд” төслийн 2018 оны хээрийн судалгааны ажлын товч дүнгээс. УБ., 2018. -//“Монголын археологи - 2018” эмхэтгэл.
5. Д.Баярсайхан “Завхан аймгийн нутаг дахь хот суурингийн зарим дурсгал” УБ., 2018. Volume 14 (13). Тал 149-162. -//“Journal of Archaeology, History and Culture”.
6. Д.Баярсайхан “Улиастай хот ба Торгоны зам” УБ., 2019. -//“Торгоны замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг” ОУЭШХ-ын эмхэтгэл.
7. Д.Баярсайхан “Хангайн нурууны ар биеэр нутаглах угсаатны бүлгүүд: Гарал угсаа түүхээс” УБ., 2019. Volume 15 (14). Тал 149-162. -//“Journal of Archaeology, History and Culture”.
8. Г.Бямбарагчаа "Хангайн нурууны ар биеэр нутаглах хүн ардын аман түүхийн судалгааны тойм" УБ., 2019. Volume 15 (14). Тал 149-162. -//“Journal of Archaeology, History and Culture”.
9. Б.Галбадрах "Хангайн нурууны ар бие дэх түүх соёлын дурсгалын тойм" УБ., 2019. Volume 15 (14). Тал 149-162. -//“Journal of Archaeology, History and Culture”.

3.3. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ

1. Д.Баярсайхан, Ө.Жадамба “Поврон хэмээх дурсгалын тухай” УБ., 2017. -//“Завхан хөгжлийн шийдэл - 2017” хуралд хэлэлцүүлсэн илтгэл.
2. Д.Баярсайхан “Хангайн нурууны ар бие дэх зарим хот суурин” УБ., 2018. -// “Нүүдэлчид ба хот суурин” ОУЭШХ-д хэлэлцүүлсэн илтгэл.
3. “Улиастай хот ба Торгоны их зам” УБ., 2019. -//“Торгоны замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг” ОУЭШХ-д хэлэлцүүлсэн илтгэл.

3.4. ХЭЭРИЙН СУДАЛГАА

«Хангайн нурууны ар бие дэх ард түмний түүх, соёлын судалгаа» суурь судалгааны төслийн хүрээнд нийт 2 удаагийн хээрийн судалгааны ажлыг 2017, 2018 онуудад тус тус Завхан, Архангай, Хөвсгөл аймгуудын нутагт хийж гүйцэтгэсэн. 2 удаагийн хээрийн судалгааны ажлын хүрээнд нийт 30 орчим хүнтэй уулзаж, аман түүхийн судалгааны эх хэрэгдэгдэхүүн материал цуглуулж, археологийн дурсгалт газруудын бүртгэл, баримтжуулалт хийж, аймгуудын төрийн төв архив, музей, номын сангуудад сууж гар бичмэл, бусад биет дурсгалуудын бүртгэл, баримтжуулалт хийсэн.

2017 оны хээрийн судалгаа

Тус хээрийн судалгааны ажилд Түүх, археологийн хүрээлэнгийн С.Бадамхатаны нэрэмжит Угсаатны судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан Г.Бямбарагчаа, Улаанбаатарын Их сургуулийн Түүхийн тэнхимийн эрхлэгч доктор (Ph.D), профессор Д.Баярсайхан, тус тэнхимийн багш Г.Галбадрах, Завхан аймгийн аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Б.Жавхлан нар оролцсон бөгөөд төслийн удирдагчаар академич С.Чулуун ажиллав. Хээрийн судалгааны ажлыг үндсэн 3-н чиглэлээр хийсэн бөгөөд үүнд:

1. Хангайн нурууны ар бие дэх ард түмний түүхэн үйл явц
2. Хангайн нурууны ар бие дэх ард түмний болон газар орны аман түүхийн судалгаа

3. Хангайн нурууны ар бие дэх түүхийн дурсгалт газрууд, археологийн дурсгалуудын бүртгэл, баримтжуулалт гэсэн үндсэн 3-н чиглэлээр судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Бидний хээрийн судалгаа анх хийсэн төлөвлөгөөгөөр

1. Улиастай сум

2. Яруу сум

3. Түдэвтэй сум

4. Тэс сум

5. Баянтэс сум

6. Нөмрөг сум


7. Тэлмэн сум

8. Идэр сум

9. Тосонцэнгэл сум

10. Их-Уул сум гэсэн чиглэлээр явах байсан хэдий боловч ажлын нөхцөл байдал болоод бусад шалтгааны улмаас Баянтэс болон Тэс сумуудаар орох боломжгүй болсон юм. Харин судалгаа хийсэн бүс нутгийн байршил, ажлын нөхцөл байдлаас шалтгаалан судалгаа хийх нэг сумд Баянхайрхан сумыг нэмэж оруулсан. Хэдийгээр анхны төлөвлөгөөгөөр хээрийн судалгаа яваагүй хэдий боловч энэ нь бидний хээрийн судалгааны үндсэн чанарт сөрөг нөлөө үзүүлээгүй бөгөөд дараагийн хээрийн судалгааны ажлаар өмнө ороогүй сумуудаар орох боломжтой гэж үзсэн болно.

Хээрийн судалгааны үндсэн хугацаа 14 хоног байсан бөгөөд нийт 20 орчим хүнээс нутаг орон, алдартай хүмүүс, түүхэн үйл явдал гэсэн чиглэлүүдээр аман түүхийн эх хэрэглэгдэхүүн цуглуулав. Мөн Завхан аймгийн музей, номын сан, төрийн төв архивт ажиллаж, зарим нэг архивын баримт сэлт, гар бичмэлүүдийг шинээр судалгааны эргэлтэд оруулав.



Халхын Сайн ноён аймгийн Чин сүзэгт Номун ханы шавь нараас өргөсөн нэгэн цэс илрүүлэв. Тэрхүү цэсэнд мөнхүү Номун хан хутагтын уг эхийг байцаан тэмдэглэсэн зүйлсийг багтаажээ. 10 см х 20 см хэмжээтэй, шарласан муутуу цаасан дээр монгол бичгээр бичсэн. Нийт 7 нүүр.

Мөн түүнчлэн утга зохиолын дурсгал болох “Арван зүгийн ажай Гэсэр хааны гучин баатраа дагуулж умар зүгийн уулын чинээ хар эрээн барс мангасын хувилгааныг ялсан нөгөө бүлэг” хэмээх гар бичмэл хадгалагдаж байна. Тус гар бичмэл нь 10 см х 20 см хэмжээтэй, шар өнгийн муутуу цаасан дээр монгол бичгээр нийт 24 нүүр бүхий байна.

Монгол бичгээр бичсэн “Си Чи Хүй хэмээх түүх. Хорин гуравдугаар бүлэг” хэмээх гар бичмэл мөн хадгалагдаж байна. Нийт 77 нүүр бүхий.

“Эргэлийн хааны судар оршвой” хэмээх монгол

бичгээр бичсэн 16 нүүр бүхий судар байна.

“Том хутагт, том ноён эцэг ах дүү нарт тус бүрт нь” хэмээх нэгэн сонин гар бичмэл байна. Мөнхүү гар бичмэлийг гарчигийг нь хожим төмөр хошуутай үзгээр бичсэн боловч доторх монгол бичгийн зурлага нь бийрээр бичсэн байна. Нийт 22 нүүр.

Бас нэгэн сонин дурсгал бол “Бадаргуулалт төрийн арван хоёрдугаар оны долоон сарын арван долооны өлзий бүрдсэн сайн өдөр Засагт хан аймгийн Самади багш Ялгуусан хутагт танаа бат оршил өргөх бэлэглэсэн наадамд барилдуулсан бөх оноолсон данс” хэмээх бичмэл юм. 20 см х 22 см хэмжээ бүхий зоолон цайвардуу цаасан дээр бичсэн тус бичмэл нь нийт 51 нүүр бүхий юм. Нийт 9 даваа бүхий барилдаан болсон байх бөгөөд давааг үе хэмээн тэмдэглэж, үе бүрт барилдсан бөхчүүдийг цол, арьяалалтай нь бичин үлдээжээ.

Дараагийн нэгэн сонирхолтой дурсгал бол “Хас хуурцаг нэрт билэг” хэмээх 281 нүүр бүхий зурхайн судар юм. 11 нүүрэнд зурхайн холбогдол бүхий зургийг багтаан оруулжээ.


- Архивын баримт

Завхан аймгийн архивын үйл ажиллагаатай танилцан фонд, данс хөмрөгийн бүртгэл мэдээлэлтэй нэг бүрчлэн үзэж танилцан, судалгааны эргэлтэнд ороогүй, бага судлагдсан баримтуудтай ажиллав. Энэ хүрээнд аймгийн архивт Ф-135, Д-1, ХН-1-д хадгалагдаж буй “Үзмэрийн зүйлийн баяжуулах, эрж сурвалжлах, аялал явуулсан тухай тайлан илтгэл” хэмээх баримтыг судлан үзэв.

Монгол орныг угсаатны зүйн талаас нь шинжлэх ажил 1921 оны хувьсгалын дараа идэвхиж улмаар 1921 оны 11-р сард байгуулагдсан Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтэд Монгол орноор аялан явж хайгуул хийн түүх, соёл, угсаатны холбогдол бүхий зүйлсийг цуглуулж эхэлсэн байна. Улмаар тэдгээр цуглан ирсэн эх хэрэглэгдэхүүнээр номын сан, музей зэргийг байгуулжээ. Завхан аймгийн нутагт музей байгуулсан түүх 1925 оны үед хамаарах бөгөөд Улиастай хотод Орон нутаг судлах музейг байгуулсан ажээ. 1959 онд Орон нутаг судлах музейн эрхлэгч Х.Эрдэнэцогт гуай өөрийн оролцоотойгоор хөдөөгийн сумуудаар явж, тус сумуудын нугат дэвсгэр дээрх түүх, соёлын бүртгэл хийж, музейн сан хөмрөгөө баяжуулах ажлыг эрхлэн явуулсан ажээ. Энэхүү хайгуулын ажлын тайлангийн нэг хэсэг нь энэхүү тайлан болно. Завхан аймгийн Түдэвтэй, Нөмрөг, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Отгон, Шилүүстэй сумдад ажилласан тайлан багтжээ.



Тус тайлангаас харахад музейн гол ажил болох үзмэрийг олон нийтэд дэлгэн үзүүлэхийн тулд энэхүү хайгуулын ажлыг эрхлэн явуулсан 1959 онд Завхан аймгийн сумдад музей байгуулагдаж харахан амжаагүй байв. Тиймээс аймгийн Орон нутаг судлах музейн зүгээс сумдад үүдлийн үзэсгэлэнг зохион байгуулдаг байжээ.

Энэхүү тайлан нь ерөнхий агуулгын хувьд Түдэвтэй, Нөмрөг, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Отгон, Шилүүстэй сумдад ажиллан, байгаль газар зүй, түүх соёлын дурсгал, хүн зоно амьдралын хэв маягт шинжилгээ хийн харьцуулан судалж бичсэн нь харагдана. Түүнчлэн Монгол орныг угсаатны зүйн талаас нь судлан шинжиж байсан түүхийн судалгаанд шинэ зүйл байна. Тус тайлан нь А4 хэмжээтэй хуучны бичгийн машины бор цаасан дээр гараар бичсэн байх бөгөөд нийт 67 нүүр, картонон гадартай.



Археологийн хайгуул судалгаагаар нийт 50 орчим дурсгалуудыг бүртгэж, байршлыг нь тогтоон, зурагжуулж тэмдэглэгээ хийв. Тэр дунд Улиастай хотын орчимд хадгалагдаж буй эртний хадны оршуулга байж болох нэгэн агуйг шинээр илрүүлж, бүртгэл хийв.



“Халхын Сайн ноён аймгийн Чин сүзэгт Номун ханы шавь нараас өргөсөн цэс”



Handwritten text in a cursive script on aged paper, consisting of approximately 12 vertical columns of text.

Handwritten text in a cursive script on aged paper, consisting of approximately 12 vertical columns of text.


“Арван зүгийн ажай Гэсэр хааны гучин баатраа дагуулж умар зүгийн уулын чинээ хар эрэн барс мангасын хувилгааныг ялсан нөгөө бүлэг”



Handwritten text in vertical columns on aged paper, likely a manuscript or historical document. The text is written in a cursive style and is organized into several columns across two pages. The characters are dense and difficult to decipher without specialized knowledge of the script.

Handwritten text in vertical columns on aged paper, likely a manuscript or historical document. The text is written in a cursive style and is organized into several columns across two pages. The characters are dense and difficult to decipher without specialized knowledge of the script.



“Си Чи Хүй хэмээх түүх. Хорин гуравдугаар бүлэг”



Handwritten text in a cursive script on aged paper, likely a manuscript or letter. The text is arranged in vertical columns, reading from right to left. The paper shows signs of wear, including creases and discoloration.

Handwritten text in a cursive script on aged paper, likely a manuscript or letter. The text is arranged in vertical columns, reading from right to left. The paper shows signs of wear, including creases and discoloration.



“Эргэлийн хааны судар оршвой”



Handwritten Japanese text on two pages of aged paper. The right page contains approximately 15 lines of text, and the left page contains approximately 15 lines. The characters are written in a cursive style (sōsho).

Handwritten Japanese text on two pages of aged paper, identical to the top image. The right page contains approximately 15 lines of text, and the left page contains approximately 15 lines. The characters are written in a cursive style (sōsho).



“Том хугагт, том ноён эцэг ах дүү нарт тус бүрт нь”





Handwritten Japanese text on two pages of aged paper. The right page contains a circled number '3' and several lines of text, including '是日...'. The left page contains vertical columns of text, some starting with '是日...'. The ink is dark and the paper shows signs of age and wear.



Handwritten Japanese text on two pages of aged paper. The right page contains a circled number '5' and several lines of text, including '是日...'. The left page contains vertical columns of text, some starting with '是日...'. The ink is dark and the paper shows signs of age and wear.


“Бадаргуулалт төрийн арван хоёрдугаар оны долоон сарын арван долооны өлзий бүрдсэн сайн өдөр Засагт хан аймгийн Самади багш Ялгуусан хутагт танаа бат оршил өргөх бэлэглэсэн наадамд барилдуулсан бөх оноолсон данс”





“Хас хуурцаг нэрт билэг”





“Үзмэрийн зүйлийн баяжуулах, эрж сурвалжлах, аялал явуулсан тухай тайлан
илтгэл”

Фр № 135
Д. № 1
ХН № 1

Завхан аймаг
ОНС МУЗЕЙ.

Үзмэрийн зүйлийн баяжуулах
эрж сурвалжлах аялал
явуулсан тухай тайлан
илтгэл;

ДХ-1959-6-5
ДУУ-1959-12-21.

1959-6-5

№1

Төвхлэнс хос

Хайгуулын тайлан

Түүдэвтэй сумын зарим нутгаар
эвэт амилласан тухай.

Албан томилогчийн 10 хоногос эрж, огцхын
2-хоногийг хасаад бүгд 8 хоногос 3 хоног
нүүдлийг үзэсгэлэнг нээт амилласан утвр үлдсэн
5 хоногийг Түүдэвтэй сумын нутаг Довонжоб, ар-
улаачин, Мөст, Мухар-тосон, Хунт, Шаврын-гол,
Хавкгайт, Хутирт, Нолрог сумын Наран зэрэг
9-газраар 120 км-д морь ба машинаар эвэт
Хуучин хурагдсан мэдээ 10-ын шалгасаны дээр
байгалийн байдал, газар нутаг, жохилдсон хэргис-
үүр, хөшөө нулуу, Хуланы тариалангийн суваг,
ан амьтан, урагмал, гол-нуур, мал ат ажув,
зан суртгуун, ат амьдралын байдалуудыг ёронхийг
нь амилгалт түүнд холбогдох зарим дээт
үзмэрийг зуулулав.

§1

1, Газар нутаг байгалийн байдалын талаар амилгахад
одоогоос 30-жилийн өмнө буюу 1929 онд байсангай
Харинцуулахад газар нутгийн хэлбэр дүрс
өөрчлөгдөөгүй боловч өвс урагмал, ан амьтан,
ус, зэргийн талаар жинг өөрчлөлт гарчээ:
а, Газрын урагмалын гарч нь 30 жилийн өмнө
одоо байгаагаас давуу байсан нь олон зүйлээр
байлагдаж байна. Зөвхөн Шаврын голын
захын ширэгийн өмнө өвсд тугал ба

Бог мал байх нь үзэгдэгдэгч байсан бол 2
одоо 1959 оны 6-р сарын 29-нд уул өвдөнх
Хамгийн өндөр нь 20-санг, нам урагсан газар нь
5 санг буюу түүнээс доош байна. Төвч нутгийн
ардуудын ариалаар бол энэ зун өвдс урагмал нь
уригжилцээс илүүтэй сагхан урагсан гэт
баяртай ариг байна. Одоогийн ургам багца
өвдс нь их төвдс толговлж байгаа нь өндөр
ургам мадаггүйн шинж юм.

Өөр нэг барамыг дуривал гишүүнэ гэдэг
игдэг зэрлэг нөгөө бол 30-аад тилтий өмнө
20-30- орчим сани өндөр ургадаг байсан
бол одоогоор 10-15 сангаас хэвэрэхгүй байна.

Элсэнд ургадаг зэрэг мууван бол уриг
элбэг ургадаг байсан нь одоо цөөн снгрэг
ургасан байна. Ингэж өвдс урагмалын ургамын
хэлтээ тил тунгал муудат байгаа нь хэвдс
үндсэн шалгаанаас болжээ:

- а, Хур бороо бага ордог.
- б, зун оройтон, нарлар эрб болт хубиэжнх
хэлтээ их болт зүний дулаан нэг
богино болсоноос болжээ.

БАН амьтадын талаар онцын өөрлөлийгүр, нийн
орших тархмал ан амьтан хөвдэр байх болол
жонын алт үндсэндс уелгат мадсан улираас
малгын хөдөлмөрийн нэгэн талаар хөнгөн
болгожээ.

Түүдэвчээс сүлмын нундгыг зөвхөн Дунд-Хамар
гэдэг уулын оройг одоогоос 30-аад тилтий өмнө
хэдхэн хамар тарваг багдгийн уригын ангад өдөрчин
сахит багт ганц, хоёрын алдг байсан бол одоо
энэ уул ба түүнийг бэлгэл, хавцгайтын ам
зэрэг газруудаар тарвага маш их элбэг болт

2018 оны хээрийн судалгаа

Судалгааны баг 2018 оны 07 сарын 27-ноос 2018 оны 08-р сарын 08-ны өдөр хүртэл Завхан аймгийн зүүн талын сумууд, Хөвсгөл аймгийн баруун талын сумууд буюу Хангайн нурууны зүүн хойд хэсэгт хамаарах сумуудын нутагт археологи, түүх, угсаатны зүйн хээрийн судалгааг хийж гүйцэтгэсэн

Тус хээрийн судалгааны ажилд Г.Бямбарагчаа, Д.Баярсайхан, Г.Галбадрах, Б.Жавхлан нар оролцсон бөгөөд төслийн удирдагчаар академич С.Чулуун ажиллав.

Хээрийн судалгааны ажлыг үндсэн 3-н чиглэлээр хийсэн бөгөөд үүнд:

1. Хангайн нурууны ар бие дэх ард түмний түүхэн үйл явц
2. Хангайн нурууны ар бие дэх ард түмний болон газар орны аман түүхийн судалгаа
3. Хангайн нурууны ар бие дэх түүхийн дурсгалт газрууд, археологийн дурсгалуудын бүртгэл, баримтжуулалт гэсэн үндсэн 3-н чиглэлээр судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хээрийн судалгаа хийсэн бүс нутгуудад дээр дурдсан чиглэлээр судалгаа төдийлэн их хийж байгаагүй бөгөөд ялангуяа түүх, угсаатны зүйн хээрийн судалгаа бараг хийгдээгүй өдийг хүрсэн бүс нутаг юм. Тиймээс энэ бүс нутаг нь түүх, соёл, угсаатны зүйн судалгааны хувьд ихээхэн чухал, анхаарал татах бүс нутаг юм.


Судалгаа хийсэн бүс нутаг нь байршлын хувьд Монгол улсын Баруун Монгол буюу Ойрад угсаатны бүлэг хийгээд халх угсаатны бүлэгт хамаарах хүмүүсийн бараг хил гэж хэлж болох бөгөөд тэр чинээгээрээ түүх, угсаатны зүйн хувьд ихээхэн сонирхолт татах бүс нутаг болох юм.

1950-аад оны сүүл үеэс Монгол улсад эхэлсэн мэргэжлийн угсаатны зүйн хээрийн судалгаа Монгол орны ихэнх бүс нутгуудад хийсээр өнөөг хүрсэн хэдий боловч бидний хээрийн судалгаа хийсэн газарт харьцангуй цөөн удаагийн судалгаа хийсэн, тэр чинээгээрээ тус бүс нутагт амьдран аж төрж буй ард түмний ахуй соёл, амьдралын хэв төрх, хүн амын бүрэлдэхүүний талаарх мэдээлэл харьцангуй хомс байсаар өдийг хүрчээ. Тиймээс энэ удаагийн хээрийн судалгааны ажил нь судалгааны хувьд ихээхэн ач холбогдол өгөхүйц хээрийн судалгаа болсон юм. Хээрийн судалгаа анх хийсэн төлөвлөгөөгөөр

1. Завхан аймгийн Идэр сум
2. Завхан аймгийн Тэлмэн сум
3. Завхан аймгийн Тосонцэнгэл сум
4. Завхан аймгийн Их-Уул сум
5. Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сум
6. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сум
7. Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сум гэсэн чиглэлээр явсан байна.

Аман түүхийн судалгаанд 13 хүнийг хамруулан Манж Чин гүрний үеэс хойш ХХ зууны төгсгөл үе хүртэлх түүхэн үйл явдал, түүхэн хүмүүс, орон нутаг зэрэг сэдвүүдийн хүрээнд аман түүхийн баримт, эх хэрэглэгдэхүүн цуглуулсан. Археологийн судалгааны хүрээнд нийт 36 хэсэг дурсгалуудын бүртгэл, баримтжуулалт, хэмжилт хийсэн бөгөөд үүнд эртний буган чулуу, булш хэрэгсүүр, тахилын байгууламж, сүм хийдийн туурь гэсэн үндсэн чиглэлүүдээр бүртгэл хийв.

Засагт хан аймгийн Ялгуусан хутагтын нутгийн зураг.




Засагт хан аймгийн Цогтой засгийн хошууны нутгийн зураг.



Их-Уул сумын Цэцүүхийн амны мэлхий чулууны зураг.



Цэцүүхийн бичээсний зураг.



Зартын хүрээнээс илэрсэн Улаан шүрэн багны зураг.



Шургахын амны хүн чулуу. /Тэлмэн сум/



Хамбын хүрээ /Идэр сум/





Ялгуусан хутагтын хүрээ /Идэр сум/







Шумуултайн хүрээ /Тосонцэнгэл сум/





Байшинтын хурал /Тосонцэнгэл сум/



Зартын хүрээ /Их-Уул сум/





Шургахын хүрээ /Идэр сум/



Бэлчирийн хурал /Тэлмэн сум/



ДҮГНЭЛТ

«Хангайн нурууны ар бие дэх түүх, соёлын судалгаа» суурь судалгааны төсөлт ажлын үр дүн нь Монголын түүх, соёлын өвийн судалгаанд зохих хувь нэмэр оруулах, Монголын түүх, археологи, угсаатны зүйн шинжлэх ухаанд Бүс нутаг судлалын чиглэлийг хээрийн судалгааны үр дүн, эх сурвалын тусламжтайгаар хөгжүүлж, Түүх, археологи, угсаатны зүйн судалгааны хүрээнд шинэ эх сурвалж, баримтуудыг шинжлэх ухааны эргэлтэд оруулж, олон нийтийн хүртээл болгон хэвлэн нийтлүүлэхийн тулд нэгэн сэдэвт бүтээл, хамтын бүтээлийг бэлэн болгож хэвлүүлэх, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүдийг олон нийтийн хүртээл болгосон. Суурь судалгааны төсөл нь Монгол дахь түүх, соёлын өвийн судалгааны салбарын хөгжилд тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулах, эх сурвалж цуглуулах, түүнийг ашиглах иж бүрэн нөхцлийг бүрдүүлэх ач холбогдолтой ажил болов. Төсөлт ажлын үр дүнгүүдийг эрдэм шинжилгээний судалгаа болон бусад чиглэлүүдээр Монголын нийгмийн бүхий л хүрээнд ашиглах боломжтой байна.

Суурь судалгааны төслийг гүйцэтгэх, санхүүжүүлэх гэрээгээр хүлээсэн төслийг гүйцэтгэх ажил, үр дүнгийн даалгаврыг хангалттай сайн гүйцэтгэж хэрэгжүүлсэн.

Суурь судалгааны төслийг гүйцэтгэх, санхүүжүүлэх гэрээгээр хүлээгээгүй үүрэг бөгөөд төслийн гүйцэтгэгч нар өөрсдийн санал санаачилгаар Монголын түүх, соёлын өвийн талаар судалгааны шинэлэг арга зүйгээр ажиллаж, эх хэрэглэгдэхүүн, баримт мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор хээрийн судалгаа хийж, түүний үр дүнгээр нэгэн сэдэвт бүтээл болон хамтын бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлүүдийг хэвлүүлж, олон нийтийн хүртээл болгоод байна.

**СЭДЭВТ АЖЛЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ КАЛЕНДАРЬЧИЛСАН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Сэдэвт ажлын хүрээнд гүйцэтгэх тодорхой үе шатны ажлууд	Эхлэх, дуусах хугацаа	Үр дүн
2017 он			
1.	Сэдэвт ажлын хүрээнд туурвих хамтын бүтээл болон нэгэн сэдэвт зохиол, толь бичгийн бүтэц төлөвлөгөө, арга зүй, үзэл баримтлалыг боловсруулна. Судалгааны үндэс болох харь хэлний сурвалжуудаас орчуулах материалыг сонгоно.	2017.01-2017.06 сар	Төслийн багийн гишүүд сэдэвт ажлын хүрээнд туурвих нэгэн сэдэвт болон хамтын бүтээлд орох үндсэн материал дээр ажиллаж, холбогдох материалуудыг үзэж танилцав.
2.	Сэдэвт ажилд холбогдох сурвалж бичиг, архивын материал, судалгааны бүтээлүүдийг уншин танилцаж, материал цуглуулна.	2017.10 сар	Монголын үндэсний төв архив болон аймгуудан төрийн архивт хадгалагдаж буй түүхэ баримтуудтай танилцаж, хуулбарлах ажлыг хийж гүйцэтгэв.
3.	Материал цуглуулах боловсруулалт хийх ажлыг үргэлжлүүлэн эрдэм шинжилгээний өгүүлэл бичнэ. Сэдэвт ажлын хүрээнд орон нутагт томилолтоор ажиллаж, археологийн малтлага судалгаа хийж, Монгол Улсын Үндэсний Төв Архиваас баримт материал цуглуулна.	2017.10-12 сар	Сэдэвт ажлын үндсэн оролцогчид тус бүр нэг өгүүлэл бичиж, хэвлэлд шилжүүлэхэд бэлэн болгов. Хээрийн судалгааны ажлын тайлан, эх хэрэглэгдэхүүнийг бэлтгэж, бэлэн болгов.
4.	Материал цуглуулах боловсруулалт хийх ажлыг үргэлжлүүлэн жилийн ажлын тайланг хэлэлцүүлж хүлээлгэн өгнө.	2017.12 сар	2017 оны төсөлт ажлын жилийн тайланг бэлтгэж, бэлэн болгов.

2018 он			
1.	Материал цуглуулах хамтын бүтээл болон нэгэн сэдэвт зохиол, толь бичгийн зарим бүлэг, зүйлийн эхний бичлэгийг хийж эхэлнэ.	2018-01-2018.12 сар	Хангайн нурууны ар бие дэх ард түмний аман түүхийн мэдээ, эх хэрэглэгдэхүүнийг нэгтгэн хэвлэлд бэлтгэв. Архивын баримтуудыг хөрвүүлж, зарим хэсгүүдийг хэвлэлд бэлэн болгосон.
2.	Нэмэлт материал цуглуулах, холбогдох зарим сурвалж бичгийг орчуулж нийтлүүлэх, эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, илтгэл тавьж хэлэлцүүлэх. Орон нутагт томилолтоор ажиллаж, археологийн малтлага судалгаа явуулж, ОХУ, БНХАУ-ын архивт томилолтоор ажиллаж, холбогдох материал цуглуулна	2018.01-08 сар	Сэдэвт ажлын оролцогчид тус бүр нэг өгүүллийг бичиж, хэвлэлд шилжүүлэв. Хээрийн судалгааг Завхан, Хөвсгөл, Архангай аймгийн нутгуудад хийж гүйцэтгэв.
3.	Нэмэлт материал цуглуулах, эхний бичлэг хийх ажлыг үргэлжлүүлэн, эрдэм шинжилгээний өгүүлэл бичих ажил хийнэ.	2018.08 сар	Аман түүх болон Архивын баримт мэдээллийг цуглуулж, хамтын бүтээлийн үндсэн бүтцийг гаргасан.
4.	Эхний бичлэг хийх ажлыг үргэлжлүүлэн жилийн ажлын тайланг хэлэлцүүлж хүлээлгэн өгнө.	2018.11-12 сар	Аман түүх, архивын баримтын эмхэтгэлийн эхний бичилтийг хийж, зохих засвар, нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан.

2019 он			
1.	Сэдэвт ажилд хамрагдах бүтээлүүдийн бүлэг зүйлийн эхний бичлэгийг дуусна.	2019.01-06 сар	Нэгэн сэдэвт бүтээлийн үндсэн бүтцийг бэлэн болгож, Хамтын бүтээлийн эхийг бэлтгэв.

2.	Эхний бичлэгийг засч сайжруулах, салбарын хурлаар хэлэлцүүлэх, эрдэм шинжилгээний өгүүлэл бичих.	2019.09-10 сар	Нэгэн сэдэвт бүтээлийг уншилтад оруулж, Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр оруулж хэлэлцүүлэв.
3.	Сэдэвт ажилд хамрагдах бүтээлүүдийг бичиж дуусган, редакцийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, зохих засвар хийнэ.	2019.11 сар	Сэдэвт ажлын хүрээнд хамрагдах бүтээлүүдийг бичиж дуусган, ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн редакцийн зөвлөлөөр хэлэлцүүлэв.
5.	Бүтээлүүдийг хэвлэлд шилжүүлэхэд бэлэн болгоно. Жилийн эцсийн ажлын тайланг хэлэлцүүлж хүлээлгэн өгнө.	2019.12 сар	Аман түүх, архивын баримт, аялагчдын тэмдэглэлийг нэгтгэн хэвлэлд шилжүүлж бэлэн болгов. Жилийн эцсийн болон сэдэвт ажлын үндсэн тайланг бэлэн болгов.

«ХАНГАЙН НУРУУНЫ АР БИЕ ДЭХ АРД ТҮМНИЙ ТҮҮХ, СОЁЛЫН СУДАЛГАА» СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ҮР ДҮНД ГАРСАН БҮТЭЭЛҮҮД

1. НЭГЭН СЭДЭВТ БҮТЭЭЛ-1

С.Чулуун, Д.Баярсайхан, Г.Бямбарагчаа, Д.Галбаяр «Хангайн нурууны ар бие дэх ард түмний түүхэнд холбогдох аман түүх, архивын баримт, аялагчдын тэмдэглэл». 30х.х, УБ., 2019

2. ХАМТЫН БҮТЭЭЛ-2

1. Д.Баярсайхан, Б.Галбаяр «Хангайн нурууны ар бие дэх түүх соёлын дурсгалууд». 25х.х, УБ., 2019.
2. Д.Баярсайхан, С.Чулуун «Хангайн нурууны ар бие дэх хот суурин, сүм хийдийн түүхийн судалгаа». 22.5х.х, УБ., 2019.

3. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ-9

1. Д.Баярсайхан “Улиастай дахь эртний хотын туурь” УБ., 2017. Volume 13 (12). Тал 71-83. -//“Journal of Archaeology, History and Culture”.
2. Д.Баярсайхан “Алдархааны зургаан ангийнхан буюу Дашпунцаглин хийдийн харьяатын түүхэн тойм” УБ., 2017. Тал 155-166. -//“STUDIA ETHNOLOGICA” Tomus XXV, Fasciculus 11.
3. Г.Бямбарагчаа “Завхан аймгийн орон нутаг судлах музейгээс хээрийн судалгаа явуулж байсан тухай” УБ., 2017. “Музей судлал” сэтгүүл.
4. С.Чулуун “XVII зууны Монголын хотууд” төслийн 2018 оны хээрийн судалгааны ажлын товч дүнгээс. УБ., 2018. -//“Монголын археологи - 2018” эмхэтгэл.
5. Д.Баярсайхан “Завхан аймгийн нутаг дахь хот суурингийн зарим дурсгал” УБ., 2018. Volume 14 (13). Тал 149-162. -//“Journal of Archaeology, History and Culture”.
6. Д.Баярсайхан “Улиастай хот ба Торгоны зам” УБ., 2019. -//“Торгоны замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг” ОУЭШХ-ын эмхэтгэл.
7. Д.Баярсайхан “Хангайн нурууны ар биеэр нутаглах угсаатны бүлгүүд: Гарал угсаа түүхээс” УБ., 2019. Volume 15 (14). Тал 149-162. -//“Journal of Archaeology, History and Culture”.
8. Г.Бямбарагчаа "Хангайн нурууны ар биеэр нутаглах хүн ардын аман түүхийн судалгааны тойм" УБ., 2019. Volume 15 (14). Тал 149-162. -//“Journal of Archaeology, History and Culture”.
9. Б.Галбадрах "Хангайн нурууны ар бие дэх түүх соёлын дурсгалын тойм" УБ., 2019. Volume 15 (14). Тал 149-162. -//“Journal of Archaeology, History and Culture”.

3. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ-3

1. Д.Баярсайхан, Ө.Жадамба “Поврон хэмээх дурсгалын тухай” УБ., 2017. -//“Завхан хөгжлийн шийдэл - 2017” хуралд хэлэлцүүлсэн илтгэл.
2. Д.Баярсайхан “Хангайн нурууны ар бие дэх зарим хот суурин” УБ., 2018. -// “Нүүдэлчид ба хот суурин” ОУЭШХ-д хэлэлцүүлсэн илтгэл.
3. “Улиастай хот ба Торгоны их зам” УБ., 2019. -//“Торгоны замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг” ОУЭШХ-д хэлэлцүүлсэн илтгэл.